



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 11/21

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хүчингүй  
болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн

**ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Шивээ-Овоо хувьцаат компани нь сумын 2 дугаар баг, Хаялга нуурын хойд талд байрлах 296000м<sup>2</sup> "Амралт сувилал"-ын зориулалтаар эзэмшиж авсан газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зориулалтын дагуу ашиглаагүй, газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй тул газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгон газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрхийг дуусгавар болгосныг Шивээ-Овоо хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшинд мэдэгдэж, холбогдох бичиг баримтыг хүлээж авахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/98 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

